

ШИНЭЭР ТОМИЛОГДСОН БОЛОН ДАДЛАГАЖИХ АЖИЛТНЫГ СУРГАХ ЗӨВЛӨМЖ

/Сайн багшийн гар дээр эх орны маргаашийн нар манддаг^{1/}

Д.Нямбат

ЦЕГ-ын Судалгаан төвийн ахлах
мэргэжилтэн, цагдаагийн хошууч

“Багш хүн...гайхалтай мэдрэгч, шавь нарынхаа дотор сэтгэлийг уншигч, өдөөгч, сэрээгч, дагуулагч, хөгжүүлэгч, урам зориг итгэл хайрлагч байх хэрэгтэй. Бүх хүн таван мэдрэхүйн сүвээ нээлттэй байлгах албагүй бол, багш хүн бүр зургаа дахь мэдрэхүйн сүвээ нээлттэй байлгах нь чухалсан”.

Багш нар тухайн салбартаа төдийгүй нийгмийн оюун санааг гэрэлтүүлэгч, хөтлөгч, чиглүүлэгч нь байдаг. Түүх эргэн сөхвөл аливаа улс орны хувьсгал, үзэл санаа, улс төрийн тогтолцооны өөрчлөлт багш нараас эхлэлтэй байсан олон тохиолдлыг мэдэж болно. Тийм ч учраас боловсролын шинжлэх ухааны доктор До.Цэнджав дээрх өгүүлбэрийг багшийн тухай яриандаа дурдсан байдаг.

Энэ нь далд буй авьяас чадвар, дайчилж чадахгүй байгаа сурлага, хөдөлмөрийн бүтээмжийг багш соргогоор мэдэрч тэдгээрийг асаах, чиглүүлэх нь чухал гэсэн агуулгатай юм. Өөрөөр хэлбэл сайн багш шавиа дэмжих үедээ сайшаан урамшуулж, буруутгах үедээ зэмлэн хэрэгтэй мөчид түлхүүрийг нь тааруулсан үед л багш шавь хоёр зорьсондоо хүрдэг. Шавийн анхны амжилт, алдаа нь багшийнх байдаг.

Хууль зүйн салбарт ажиллагсдыг “нийгмийг эмчлэгч” гэж олон иргэд үздэг тул тэдэнд алдах эрх байх ёсгүй. Иймд шинээр томилогдсон хүмүүст сурган хүмүүжүүлэгч, дадлагажуулагчийг заавал томилж ажил албанд нь богино хугацаанд сургах, дасан зохицуулах, алдаа дутагдал гаргуулахгүй байх, мэргэжлийн чиг баримжаатай болгох ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь зүйтэй юм². Ийм төслийг эрүүл мэндийн салбарынхан хэрэгжүүлж байгаа.

Жишээ нь: нийслэлийн амаржих газрууд олон жил ажилласан эх барих, сувилахуйн чиглэлээр мэргэшсэн туршлагатай эх баригч, сувилагч нарыг урин ирүүлж шинэ залуу ажилтнуудаа ажлын байран дээр нь дадлагажуулах ажлыг эхлүүлээд байна.

Хамгийн анх албан ёсоор 1972 онд АНУ-ын Калифорни мужийн Сан Хосе хотын цагдаагийн газар шинэ, залуу алба хаагч нарыг ур чадвартай, ажил үүргээ амжилттай гүйцэтгэдэг алба хаагч болгохын тулд тэдэнд илүү их анхаарал, халамж хэрэгтэйг тогтоосон судалгааны дүнг үндэслэн “ажлын байранд дадлагажуулах хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлсэн байна³.

Манай улсын цагдаагийн байгууллага ч гэсэн ялгаагүй шинэ, залуу алба хаагч нарыг хэргийн газрын үзлэг сайн хийдэг, гэмт хэргийн сэжүүр гогцоог олж чаддаг, хариуцсан хороогоо нэг бүрчлэн судалсан, хяналтандаа авч чаддаг, бүрэн бус тээврийн хэрэгсэл эсхүл согтуурсан үедээ машин жолоодож яваа иргэнийг холоос хараад мэдэрч чаддаг зэрэг хашир туршлагатай, чамбай, мэргэжлийн ур чадвар өндөр хөгжсөн мөрдөн байцаагч, төлөөлөгч, хэсгийн болон замын цагдаагийн байцаагчийг дагалдуулан ажиллуулах нь зүйтэй юм. Боловсрол дадлага хоёрыг хослуулах нь олон төрлийн ач холбогдолтой.

АЧ ХОЛБОГДОЛ

Цагдаагийн байгууллагаас дадлагажуулагч-алба хаагчийг томилж ХСИС, бусад их, дээд сургууль төгсөгчид, дадлагажих ажилтан нарыг ажилд нь сургах нь дараах ач холбогдолтой. Үүнд:

¹Т.Дашжид (2014) ярилцлага. <https://www.shuud.mn/?p=341743>

² ЦБ-ын үйл ажиллагааны журам (2011), Код: 942 хуудас 685

³Цагдаагийн шинжлэх ухаан ном (2007) Ажлын байранд дахь дадлагажуулах хөтөлбөр нийтлэл, хуудас 522

1. **Ажлыг нь чиглүүлнэ.** Онолын мэдлэг эзэмшиж сургуулийн ширээний араас ирсэн залууст “сонссон зүйл мартагддаг, үзсэн зүйл санаанд үлддэг, хийж үзсэн зүйл бүрэн ойлгогддог”⁴ гэсэн эртний үг хэдэн зуун жил мартагдаагүй оршсоор байгааг ойлгуулах нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл дадлагажуулагч-алба хаагч нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэг, өдөр тутмын мэдвэл зохих зүйлс, ажил үүргээ хэвийн гүйцэтгэх ур чадвар, дадлагыг биечлэн хийлгүүлснээр шинээр томилогдсон залуус эрхэлсэн ажилдаа амжилт гаргах болно. Жишээ нь: аливаа зүйлийг эхлэн суралцагчийн дадал хэвшил, ажлын дараалал, сурц зэрэг нь багшийн анх зааснаар хэвшиж тогтдог.

2. **Оюун санааг нь чиглүүлнэ.** АНУ-ын Иел, Харвард зэрэг их сургуульд багшилж байсан, Германы сэтгэл судлаач нэрт эрдэмтэн Эриксон нь 18-25 насны хүмүүсийн онцлогийг судлаад тэдний биологийн нас хэдийгээр хуульд зааснаар насанд хүрсэн боловч оюун санааны хувьд бүрэн боловсорч дуусаагүй байдгийг тогтоожээ. Тэрээр хэлэхдээ “сургууль төгссөн залуус бүтэн цагийн ажил хийхээр ажилд анх орох үед хэд хэдэн хүндрэлтэй асуудалтай тулгарч эхлэнэ”⁵ гэжээ. Тухайлбал гэр бүл зохиох, гэрээсээ явж бие дааж амьдрах, нийгэм болон хамт олны дунд байр сууриа эзлэх, өглөө хоцролгүй ирэх, ажилдаа туршлагажих, орлогоо зөв зарцуулж сурах зэргээр амьдралын хэв маяг бүрэн өөрчлөгдөхийн хирээр тэдний үзэл санаа, ёс суртахууны хэм хэмжээ мөн төлөвшиж байдаг байна.

Дээрх судалгаанаас үзвэл шинээр болон дадлагажих ажилтнаар томилогдсон алба хаагчид хүний эрх, эрх чөлөөг хангах, авлигаас ангид байх, хууль дээдлэх, түүнийг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл, ажилдаа дур сонирхолтой болох, ёс зүйтэй алба хаагч төдийгүй, зөв иргэн хүн болж төлөвших үйл явц нь дадлагажуулагч-алба хаагчийн хичээл зүтгэл, ур чадвар, манлайллаас шалтгаалахаар байна.

Иймд хамт олондоо нэр хүндтэй, ажилдаа идэвх санаачлагатай, шударга, хашир туршлагатай алба хаагчийг дагалдуулснаар залуусын үзэл санаа зөв зүгт чиглэгдэх юм.

3. **Амьдралыг нь чиглүүлнэ.** Шинээр болон дадлагажих ажилтнаар томилогдсон алба хаагчдын цөөнгүй хувь нь өөрсдийн хүсээгүй газар нутагт томилогдон эцэг эх, найз нөхдөөсөө хол ажлын гараагаа эхэлдэг. Сэтгэл ханамжгүй ажил, орчин нөхцөлд амьдарч буй алба хаагчаас ажлын үр дүн нэхээд нэмэргүй байдаг.

Иймд дадлагажуулагч-алба хаагч нь тэдгээр залуусыг зоригжуулагч, сурган хүмүүжүүлэгч, сэтгэл засагч, эерэг нөлөө үзүүлэгч, амьдралынх нь түшиг тулгуур нь болж ажлын гарааг зөв чиглүүлэх болно.

4. **Дадлагажуулагч-алба хаагчид эерэг нөлөөтэй.** Дадлагажуулагч-алба хаагчаар ажиллаж буй алба хаагч оюун санаа, ёс суртахуун, үзэл санааны хувьд бусдыг цэнэглэж өөр шигээ болгохын тулд тэрээр мэргэжлийн болон ёс суртахууны өндөр түвшинд очихоор тэмүүлэх болно. Мөн хэрэг, зөрчлийг хурдан илрүүлэх, шийдэх ур чадварыг биечлэн үзүүлэхээр хичээнэ.

Үүнийг Хятадын нэрт номлогч Күнзийн амьдралаас үүнийг харж болно. Тэрээр шавь нарынх нь тоо нэмэгдэх тусам өөрийгөө улам бүр боловсруулж байж. Нэг үгээр багш нар асуултанд хариулахын тулд өөрийгөө бэлдэж, байнга уншиж судалж байдаг тухай өнөө үеийн боловсролын шинжлэх ухааны ажилтнууд ч гэсэн баталж байна.

5. **Багаар ажиллах чадвар нэмэгдэнэ.** Шинээр болон дадлагажих ажилтнаар томилогдсон алба хаагчийн мөрдөн шалгаж буй хэрэг, зөрчил бүр нь тэдэнд хариу нь тодорхойгүй өгөгдөл бөгөөд дадлагажуулагч-алба хаагчийн удирдлага, заавар, зөвлөмжийн дагуу тухай бүрд нь хэрхэн ажиллах, шийдвэр гаргах, асуудлыг оновчтой шийдэж сурахаас гадна багаар ажиллах чухал шаардлагууд болох бусдыг сонсох, хүндлэх зэрэг ур чадварыг мөн эзэмшинэ.

6. **Ажлын байранд тохирсон алба хаагчийг сонгох боломж бүрдэнэ.** Тодорхой хугацааны дараа шалгуур үзүүлэлтээр шинээр болон дадлагажигчаар томилогдсон алба хаагчийг дүгнэсний эцэст түүнд ямар ажлын байр тохирох эсэхийг таних болно.

Тухайлбал эрүүгийн тагнуулын ажилд тохирох зан чанартай, сонирхол эрмэлзэлтэй, авьяастай алба хаагчийг өөр албанд ажиллуулах нь тохиромжгүй байдаг.

ШИНЭЭР БОЛОН ДАДЛАГАЖИХ АЖИЛТНЫГ СУРГАН ДАДЛАГАЖУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

⁴Confucius (МЭӨ 551–479) <http://www.brainyquote.com/quotes/authors/c/confucius.html>

⁵Erik H. Erikson, [Childhood and Society](#) (Penguin 1975) хуудас 255

Цагдаагийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлд “Цагдаагийн төв байгууллагын дарга нь цагдаагийн алба хаагч, ажилтны хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хүний нөөцийн бодлого боловсруулан, алба хаагч, ажилтныг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авна” гэж заасан.

Мөн цагдаагийн байгууллагад шинээр болон дадлагажих ажилтнаар томилогдсон алба хаагчдыг гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, мэргэжлийн ур чадварыг бий болгох, сахилга ёс зүйг төлөвшүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч байхаар дотоод журамд (код 942) тусгасан байдаг.

Хуучин уламжлалын хувьд 2000 оны эхэн үе хүртэл орон нутаг болон Улаанбаатар хотын цагдаагийн газар, хэлтсийн дарга нар шинээр томилогдсон алба хаагч нарт сурган дадлагажуулагч болон халамжлан хүмүүжүүлэгч томилж байсныг доорх тушаалын хуулбараас харж болно.

ОКТЯБРЬСКИЙ РАЙОН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ЦАГДАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТСИЙН ДАРГЫН ТУШААЛ⁶ 1990 оны 01 дүгээр Улаанбаатар хот сарын 29-ны өдөр №14 Дүгэржав овогтой Болд нь цагдан сэргийлэх байгууллагад ажиллахыг хүсч өргөдөл хүсэлт ирүүлсний дагуу шаардлагатай судалгааг хийж хамт олны хурлаар хэлэлцүүлж намын үүрийн хурлыг үндэслэн ТУШААХ НЬ: 1. Дүгэржав овогтой Болдыг эргүүлийн Сэргийлэгчээр 1990 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн томилсугай. 2. Дүгэржав овогтой Болдын сарын үндсэн цалинг 470 төгрөгөөр тогтоож цалинжуулж байхыг ня-бо ахлагч Л.Мягмарт зөвшөөрсүгэй. 3. Дүгэржав овогтой Болдыг ажил албанд нь сургах дадлагажуулах халамжлан сургагчаар ахмад Д.Баттогтохыг томилсугай. ДАРГА, ХУРАНДАА Ш.ГАНЖУУРЖАВ	ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ЦАГДАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТСИЙН ДАРГЫН ТУШААЛ⁷ 1991 оны 3 дугаар Арвайхээр хот сарын 26-ны өдөр №37 ЦООДОЛ ОВОГТОЙ НАРАНХҮҮГ АЖИЛД ТОМИЛОХ ТУХАЙ Арвайхээр хотын нефтийн гэрээт постын хамт олны хурлын шийдвэрийг үндэслэн тушаах нь: 1. Цоодол овогтой Наранхүүг 3-р сарын 15-ны өдрөөс эхлэн Нефтийн гэрээт постод гал сөнөөгчөөр томилон ажиллуулсугай. 2. Ц.Наранхүүг томилогдсон өдрөөс эхлэн 1000 төгрөгөөр цалинжуулан ажиллуулахыг ахлах ня-бо Пүрэжавт даалгасугай. 3. Ц.Наранхүүг халамжлан хүмүүжүүлэгчээр а/ч Д.Юураг томилон ажиллуулсугай. 4. Энэ тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул. ХЭЛТСИЙН ДАРГА, Д/Х П.ЛУВСАНДОРЖ
--	--

Дээрх цагдаагийн байгууллагын дарга нарын тушаалаас харахад орон нутаг болон Улаанбаатар хотод цагдаагийн газар, хэлтэст шинээр томилогдож байсан алба хаагч нарт сурган дадлагажуулагч эсхүл халамжлан хүмүүжүүлэгч томилж байсан уламжлалтай байжээ.

Дадлагажуулагч-алба хаагчийг томилж шинэ үеэ бэлддэг түүхэн уламжлалтай байсан тухай генерал Думбурай зэрэг ахмад алба хаагч, салбарын эрдэмтдийн бүтээлд тод үлдсэн байна⁸. Жишээ нь: ахмад-дунд-залуу үеийн уулзалтыг дурдаж болно.

2015 онд батлагдсан ЦЕГ-ын “Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн нийтлэг үндэслэл”-ийн 2.15.2 хэсэгт “цагдаагийн байгууллагад томилогдон ажиллах алба хаагчдын богино хугацаанд дасан зохицох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ” гэжээ.

⁶ 2015 оны 05 сарын 01-ны ЦЕГ-ын Төв архивын газрын 13/1008 албан тоот (хувь хүний нууцыг хадгалах үүднээс алба хаагчийн нэрийг нь өөрчилсөн болно)

⁷ 2015 оны 05 сарын 01-ны ЦЕГ-ын Төв архивын газрын 13/1008 албан тоот (хувь хүний нууцыг хадгалах үүднээс алба хаагчийн нэрийг нь өөрчилсөн болно)

⁸ А.Думбурай (1976) “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын үйл ажиллагаа” ном

ХСИС-ийн сүүлийн 5 жилийн төгсөгч нарын судалгааг⁹ харуулсан доорх хүснэгтээс жил ирэх бүр төгсөгч нарын тоо нэмэгдэж буйг харж болно.

д/д	Он		2010	2011	2012	2013	2014	Нийт
	Мэргэжлийн чиглэл							
1	Цагдаагийн сургууль	Цагдаагийн ажил-эрх зүй /өдөр/	91	126	129	172	220	738
2		Цагдаагийн ажил-эрх зүй /эчнээ 3 жил/	18	27	39	32	31	147
3		Цагдаагийн ажил-эрх зүй /эчнээ 5 жил/	48	46	29	59	63	245
4		Дотоодын цэргийн ажил-эрх зүй /өдөр/		16		27		43
5	Цагдаагийн стратеги-тактик, удирдлага /Удирдлагын сургууль/						2	2
6	Ахлагчийн сургууль	Цагдаа		135	220	201	197	753
7		Цагдаа-жолооч			20	26	21	67

Мөн 2015 оны 3 дугаар сард болсон ЦЕГ-ын даргын зөвлөлийн хурлын үеэр дэд дарга, дэд комиссар А.Амарсайхан “ажлын байранд шинэ алба хаагчийг яаж сургах юм, хэн хариуцах юм бэ, хариуцуулсан чиглэлийн юм огт алга...” байгааг дурдсан.

Энэ онд боловсруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 68-р зүйлийн 68.4-т “дадлагажигч ажилтан туршилтын хугацаанд албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дадлагажуулагч алба хаагчийн удирдлага дор ажиллана” гэж заасан нь дэвшилттэй зүйл болсон. Харин хууль батлагдсаны дараа шинээр томилогдсон алба хаагчийг ажилд нь хэрхэн дасан зохицуулах, мэргэшүүлэх, байр суурийг нь олуулах тухай орхигдуулж болохгүй.

Дээрхээс нэгтгэн дүгнэхэд цагдаагийн байгууллага шинээр болон дадлагажих ажилтнаар томилогдсон алба хаагчийг хэрхэн сурган дадлагажуулах, үр дүнг нь тооцох талаар нэгдсэн бодлого чиглэл, хуучин уламжлалыг өнөөдөр орхигдуулсан байна.

Иймд дараах ажлуудыг эхлүүлнэ.

ХИЙХ АЖЛУУД

Хамгийн түрүүнд газар, хэлтсийн дарга нар тушаалаар дадлагажуулагч-алба хаагчийг томилж хэвших нь зүйтэй. Үүний дараа Цагдаагийн төв байгууллага доорх аргыг ашиглаж ажлын байранд алба хаагч нарыг сургаж болно. Үүнд:

1. Сан үүсгэн мэдлэг, мэдээллээ хуваалцах. Дадлагажуулагч-алба хаагч нарын сурган хүмүүжүүлэх арга, түүний онцлог, туршлага, дадлагажуулах шинэлэг санаа, хойшид анхаарах сургамжтай үйл явдлын талаар тэднээс тайлан хэлбэрээр улирал бүр гаргуулан авч сан үүсгэн мэдлэг, мэдээллээ бусадтай хуваалцах арга юм. Тайланг нэгтгэх үүргийг Хэвлэл, мэдээллийн төв хариуцах бөгөөд энгийн үг хэллэгтэй, амьдралаас урган гарсан бодит жишээнүүд, сурган хүмүүжүүлэх аргуудыг онцлон боловсруулж түгээнэ.

Жишээ нь: тайланд шинээр томилогдсон болон дадлагажигч алба хаагчийн хандлага, ажиллаж байсан түвшин, хэрхэн туршлагажиж байгаа, үзэл бодол нь өөрчлөгдсөн эсэх, алдаа дутагдал гаргасан зэргийг тусгаснаар бусад орон нутаг, нэгжийн алба хаагч нарт сургамж болох юм.

Бусдыг гутаан доромжлох, ичээх нь тэднийг сурах, ажиллах урам зоригийг мохоох аюултай тул тодорхой алба хаагч болон орон нутгийн нэрсийг бичихгүй байх нь зүйтэй.

⁹ХСИС-ийн Сургалтын алба (2015).

2. **Дадлагажуулагч-chat ашиглах.** Гэмт хэрэг, зөрчил хэдийд ч, хаана ч үйлдэгдэж байдаг тул цагдаагийн алба хаагч нар ажлын цаг хэтрүүлэн ажиллах нь нийтлэг зүйл болоод байна. Иймд тэдний цагийг хэмнэх, мэдэхгүй зүйл гарахад нь туслах, заавар зөвлөгөө өгөх зорилгоор 24 цагийн болон 365 хоногийн ажиллагаатай “асуулт хариултын булан” болон тусгай дугаарын утсыг үнэгүй ажиллуулна.

Жишээ нь: Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч нар өдөр бүр ажлын байрандаа ээлжлэн жижүүрийн үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд ихэнх нь тодорхой хугацаанд ажилласан туршлагатай, ахлах офицер байдаг тул бусдад зааж, зөвлөх, сэтгэл зүйч байх чадвар бий. Тухайн өдөр жижүүрийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч энэхүү үүргийг гүйцэтгэнэ.

Дотоод сүлжээнд “Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газар” гэсэн хаягийг үүсгэж нийт алба хаагч нарт зарлаж мэдэгдэнэ. Харин тус газрын алба хаагч нар албаны харьцаанаас аль болох зайлсхийж эелдэг хандах, тусалж дэмжихийг урьтал болгох нь зүйтэй.

Дотоод сүлжээ ашиглах боломжгүй үед дээрх байгууллагын жижүүрийн утас, тусгай дугаарыг мөн ашиглана.

3. **Дадлагажуулах хугацаа, үр дүнг тооцох аргачлалыг боловсруулах.** Гадаад улс орны цагдаагийн байгууллагын алба хаагчаа дадлагажуулах хугацаа нь янз бүр байх бөгөөд ихэвчлэн 3-6 сар эсхүл 6-12 сар байна. Ажилдаа хир дасан зохицож буйг дадлагажигч алба хаагчийн (1) ур чадвар, (2) мэдлэг, туршлага, (3) хандлага, зан төлөвийн өөрчлөлт гэсэн гурван үндсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг.


Эдгээрийг цааш задалбал алба хаагч амь насаа хамгаалах чадвар, стрессээс хэрхэн чөлөөлөгдөж буй, бусад алба хаагч нартай болон иргэдтэй эерэг харилцаа үүсгэх, ёс зүйн алдаа, албаны бичиг баримт хөтлөлт, техник хэрэгслийн ашиглалт, багаар болон бие дааж ажиллах, үзэл бодлоо зөв илэрхийлэх, шүүмжлэл хүлээн авах, цаг ашиглалт зэрэг олон төрлийн ур чадварыг эзэмшсэн эсэхийг тодорхойлж болно.

Гэхдээ тухайн байгууллагын онцлог, хэрэгжүүлж буй үүргээс шалтгаалан шалгуур үзүүлэлт нь өөр өөр байна. Иймд үр дүнг тооцох аргачлалыг байгууллага бүрийн төлөөллийг багтаасан ажлын хэсэг байгуулан боловсруулна.

ДАДЛАГАЖУУЛАГЧ-АЛБА ХААГЧИЙГ ТОМИЛОХОД АНХААРАХ ЗҮЙЛ

Цагдаагийн байгууллагын байршил, тухайн нутаг дэвсгэрийн эрүү, захиргаа, хэв журмын нөхцөл байдал, хэргийн гаралт, голчлон үйлдэгддэг хэргийн төрлүүд, тухайн нутгийн иргэдийн хэл, соёл, заншил зэрэг нь өөр хоорондоо адилгүй байхаас гадна шинээр болон дадлагажих ажилтнуудын хүмүүжил, боловсролын түвшин, өссөн орчин, үзэл санаа нь нэгэн хэвд цутгасан байдаггүй тул дадлагажуулагч-алба хаагчийг томилж буй удирдах албан тушаалтан дараах нийтлэг зүйлийг анхаарах нь зүйтэй юм. Үүнд:

1. **Дадлагажуулагч-алба хаагчийг цаг алдалгүй томилж байх.** Доорх графикаас харахад алба хаагчийн ажилласан жил нэмэгдэх тусам ажлын туршлага нэмэгдэнэ. Гэвч түүний биеэ даах, бусдыг үл тоох, бүгдийг мэддэг чаддаг гэдэгтээ итгэх муйхар зан ажилласан жилтэйгээ цуг өссөөр байгааг мөн харж байна.



Өөрөөр хэлбэл тодорхой хугацаанд ажилласан, нас нь тийм ч залуу биш алба хаагчийг сурган дадлагажуулах нь түвэгтэй байдаг гэсэн үг. Жишээ нь: графикаас дүгнэхэд 5 жил ажилласан алба хаагч анх ажилд орж байсан үеэсээ 25%-р өөрчлөгдсөн байна.

Иймд ажлын гараагаа эхэлж буй залуусыг сурган дадлагажуулах ажлыг нэн яаралтай, зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж байх нь чухал байна.

2. Дадлагажуулагч-алба хаагч хамт олондоо нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн байх. Өөрөөр хэлбэл хамгийн удаан жил ажилласан нь сайн байж таарна гэсэн явцуу ойлгох бус цөөн боловч үр бүтээлтэй ажилласан алба хаагчийг сонгож болно.

Жишээ нь: “Цагдаагийн шинжлэх ухаан” номны биологийн насны онцлогийг өгүүлсэн нийтлэлд “залуус ажилдаа дур сонирхолтой байх, хамт олны эерэг уур амьсгал, спортын идэвхтэй арга хэмжээ, хамт ажиллагсадтайгаа дотно сайн харилцаатай байх нь тэдний алдаа гаргах, буруу тийш чиглэх эрсдлийг бууруулдаг” гэдгийг дурджээ.¹⁰ Эндээс үзэхэд дадлагажих болон шинээр томилогдсон алба хаагчтай нас ойролцоо болон ижил хобби, сонирхолтой дадлагажуулагч-алба хаагч нь дээрх нөхцөл байдлыг бүрдүүлэх боломжтой.

3. **Дадлагажуулагч-алба хаагчид урамшуулал олгох.** Жишээ нь: цалингийн нэмэгдэл. Ийм тохиолдолд дадлагажуулагч-алба хаагч нь бусдыг сурган дадлагажуулах хугацааг хариуцлагатай, үр дүнтэй өнгөрөөх болно. Нэг үгээр өөрийнхөө өмнөөс мэдүүлэг авахуулах, тамхи авахуулахаар дэлгүүр гүйлгэх зэргээр зарим алба хаагч нарын гаргадаг албаны бус харилцаа цөөрнө.
4. **Дадлагажуулагч-алба хаагч нь хөдөлмөрийн аварга байх албагүй юм.** Зарим тохиолдолд байгууллагын ажил мэргэжлийн аваргаар удаа дараа шалгарч байсан, маш хурдан шуурхай ажилладаг алба хаагч нар бусдад өөрийн сурсан мэдсэн зүйлээ заах, илэрхийлэх арга дүй муутай байх тохиолдол бий. Харин ийм хүний оронд зан төлөвийн хувьд удаан боловч ажлаа эмх цэгцтэй хийдэг, төлөвлөдөг, ёс зүйтэй, хуулийн зүйл заалт бүрийг баримталж ажилладаг, бусдад зааж сургах эрмэлзэлтэй алба хаагчийг сонгох нь зүйтэй.

ДҮГНЭЛТ

“Жилийнхээ ургацыг авъя гэвэл үрийг нь тарь, арван жилийн ургацаа бэлдье гэвэл модыг нь тарь, харин 100 жилийн ургацаа авъя гэвэл бусдад зааж өг” хэмээх эртний сургаалиас үзвэл цагдаагийн байгууллага алба хаагч нэг бүрийг сургах, дадлагажуулах, кредит цаг цуглуулах шаардлага тавихаасаа илүүтэй тодорхой хугацаанд ажиллаж туршлага хуримтлуулсан, ёс суртахуунтай, хууль ёсыг дээдлэгч, мэргэжлийн өндөр ур чадвартай алба хаагч нарыг улам бүр мэргэшүүлэх, манлайлах чадварын сургалт явуулах нь мянга мянган чадварлаг алба хаагчтай болох үндэс нь байх болно.

Жишээлбэл цагдаагийн байгууллагаас мөрдөн байцаагч бүрт хэргийн газрын үзлэгийг чанартай, төгс, хууль ёсны дагуу хийдэг ур чадвар-ээзмшүүлэхийн тулд нэгж дээр байгаа ахлах мөрдөн байцаагч буюу дадлагажуулагч-алба хаагч нарын энэ чадварыг улам бүр хөгжүүлэх ажлыг эхлүүлэх нь зүйтэй байна.

2011 онд “цагдаагийн байгууллын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх” 942 дугаартай код бүхий журам батлагдсан хэдий ч ажлын байранд алба хаагчийг сургах ажиллагаа тодорхой үр дүнд хүрэхгүй байх тул сайн багшийн гар дээр эх орны өглөөний нар манддаг гэдгийг энэ нийтлэлээр харуулахыг зорьлоо.

¹⁰The Encyclopedia of Police Science (2007). *Age and Crime* 3 дахь хэвлэл. Хуудас 31.